



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/30

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 23 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд олон нийтийг хамарсан урлаг соёлын арга хэмжээ, уралдаан тэмцээн, хурим найр, сургалт семинар зохион байгуулахыг хориглож хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Коронавирус (КОВИД-19)-ийн нөхцөл байдалтай холбогдуулан сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд тухай бүр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Дундговь аймгийн хэмжээнд коронавирус (КОВИД-19)-ийн халдвараар өвчилж гэрээр эмчлэгдэж байгаа болон гэрийн ажиглалтад байгаа ойрын хавьтлын иргэдэд хяналт тавих арга хэмжээг эрчимжүүлэхийг аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Тагнуулын газар, Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зэрэг тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дарга, удирдлагуудад даалгасугай.

4. Аймгийн Биеийн тамир спортын газар дээр иргэдэд үйлчлэх эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээг байгуулж ажиллуулах, коронавирус (КОВИД-19)-ийн халдвараар өвчилсөн иргэдэд эмчилгээний багц тараах, эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж өгөх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 547 дугаар тушаалаар батлагдсан коронавирус (КОВИД-19)-ийн халдварын шинж тэмдэг илрээгүй, сайн дураар шинжилгээ өгч байгаа иргэдээс төлбөртэй шинжилгээ авах журмыг мөрдөж ажиллахыг Сумдын Засаг дарга нар, Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т тус тус үүрэг болгосугай.

481210408

6. Коронавирус (КОВИД-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын 3 дугаар тунд идэвхтэй хамрагдаж, халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.

7. Хорио цээрийн дэглэмийн дараах малын гоц халдварт өвчний идэвхгүй тандалт хийх эрсдэлийг үнэлэх ажлын хэсэг ажиллуулах, малчин нэг бүртэй хариуцлагын гэрээ байгуулж малчдын мал эмнэлгийн арга хэмжээ, мал эмнэлгийн холбогдолтой журам заавар, хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг мөрдүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Сумын хэмжээнд отор нүүдлийг нэгдсэн төлөвлөлтөөр зохион байгуулах малчдын гар тэжээлийг нормын дагуу бэлдүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ